



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 17-өдөр

Дугаар 4/178

Мандалговь

Гамшигаас хамгаалах сургууль, үзлэгийг зохион байгуулах тухай

Гамшигаас хамгаалах тухай хуулийн 13.3.2, 32.1.1, 51.4 дэх заалтууд, Монгол Улсын Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалтын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь хэсэг, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны дүгээр хурлын тэмдэглэл, Аймгийн Засаг даргаас Онцгой байдлын газрын даргатай байгуулсан менежерийн үр дүнгийн гэрээний 1.2.3, 1.2.4 1.2.5 1.2.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын нэрэмжит Гамшигаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг Дэрэн суманд 2018 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс 03-ны өдрүүдэд,

- Гамшигаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг Цагаандэлгэр суманд 2018 оны 05 дугаар сарын 04-ны өдрөөс 05 дугаар сарын 06-ны өдрүүдэд,
- Гамшигаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг Баянжартгалан суманд 2018 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс 05 дугаар сарын 10-ны өдрүүдэд,
- Гамшигаас хамгаалах иж бүрэн сургуулийг Сайнцагаан суманд 2018 оны 05 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд,
- Гамшигаас хамгаалах удирдах бүрэлдэхүүний сургуулийг Дэлгэрхангай суманд 2018 оны 10 дугаар сарын 01-ны өдрөөс 03-ны өдрүүдэд,
- Гамшигаас хамгаалах иж бүрэн сургуулийг Адаацаг суманд 2018 оны 10 дугаар сарын 04-ны өдрөөс 07-ны өдрүүдэд, тус тус зохион байгуулсугай.

Хоёр. Гамшигаас хамгаалах албадын үзлэгийг "Хүнс хөдөө аж ахуйн алба", "Зам тээврийн алба", "Эрүүл мэндийн алба"-дад, 10 дугаар сард тус тус явуулж гамшигаас хамгаалах бэлэн байдлыг ханггуулж ажиллахыг Онцгой байдлын газар /Онцгой байдлын хурандаа Я.Алтанхундага/-т үүрэг болгосугай.

Гурав. Гамшигаас хамгаалах сургууль, үзлэг зохион байгуулах бүрэлдэхүүнийг 1 дүгээр, шаардагдах зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

0230526

Дөрөв. Гамшгаас хамгаалах сургууль, үзлэгийг зохион байгуулахад шаардагдах 2.646.868 /Хоёр сая зургаан зуун дөчин зургаан мянга найман зуун жаран найм/-н төгрөгийг Засаг даргын неөцийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан /Г.Мөнхбаясгалан/-д зөвшөөрсүгэй.

Тав. Гамшгаас хамгаалах сургууль, үзлэгийг батлагдсан бодлого, төлөвлөгөө, удирдамжийн дагуу явуулж дүнг 2018 оны 11 дүгээр сарын 01–ны дотор танилцуулахыг сургуулийн удирдагч /Онцгой байдлын хурандаа Я.Алтанхундага/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О. БАТ-ЭРДЭНЭ

